



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

Хөрөнгө дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 220,267,526.00 (хоёр зуун хорин сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун хорин зургаан) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Хөвсгөл-АЗЗА" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Ажлын хэсэг томилон үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашиныг автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001372

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 05
дугаар сарын 20-ны өдрийн
168 дугаар тогтоолын хавсралт

"Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн жагсаалт

№	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад/ Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ, Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1	Мицубиши маркийн 68- 65 ХӨА улсын дугаартай, суудлын автомашин, Арлын дугаар JMYLRV93W9J000311	2008/2010	96,991,902.00	3,000,000.00
2	Донгфенг маркын ачааны автомашин, 18-78 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH39660403	2009/2009	34,425,208.00	2,000,000.00
3	Донгфенг маркын ачааны автомашин, 18-79 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH19660405	2009/2009	34,425,208.00	2,000,000.00
4	Донгфенг маркын ачааны автомашин, 18-82 ХӨВ улсын дугаартай, арлын дугаар- LGAWAHAAH496604054	2009/2009	34,425,208.00	2,000,000.00
5	Краз 255 маркын механизм, 6455 ХӨА улсын дугаартай, арлын дугаар-370841	1980/1988	20,000,000.00	1,500,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		220,267,526.00 (хоёр зуун хорин сая хоёр зуун жаран долоон мянга таван зуун хорин зургаан)	10,500,000.00 (арван сая таван зуун)